



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 8/97

Мандалговь

Г Тэмцээн зохион байгуулах тухай Т

Батлан хамгаалахын сайдтай 2017 онд байгуулсан гэрээний 3.2.8 дах заалт, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3 дах заалт, Аймгийн засаг даргын 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 5 дугаар зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017 оны 09 дүгээр сард Улсын аварга шалгаруулах цэрэгжил спортын “Дөл” тэмцээн болохтой холбогдуулан аймгийн МСҮТ, ерөнхий боловсролын сургуулиудын дунд явуулах цэрэгжил спортын “Дөл-2017” тоглолтыг батлагдсан удирдамжийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж явуулсугай.

Хоёр. Дээрх тоглолтыг хүүхэд залуучуудад цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр болохуйцаар зохион байгуулж явуулахыг аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Б.Амаржаргал, Боловсрол Соёл урлагийн газрын дарга Ц.Бумангэрэл, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн захирагч хошууч Д.Ганболд нарт даалгасугай.

Гурав. Тэмцээний шүүгчээр цэргийн штабын ОНХ, сургалтын офицер хошууч Ш.Гансүх, Зэвсэгт хүчний 278 дугаар байгууламжийн сургалтын офицер дэслэгч М.Ууганбаяр, Биеийн тамир спортын газрын мэргэжилтэн С.Цолмон нарыг томилсугай.

Дөрөв. Дээрх арга хэмжээнд шаардагдах 594.000 /Таван зуун ерэн дөрвөн мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваад/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



020000255